# САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЕСДҮГЭЭР САР 2020

## ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт*

**ДНБ**
-9.7%
2020 оны II-р улирлын байдлаар

**ИНФЛЯЦИ**
1.7%

**ТӨГРӨГИЙН АМ.ДОЛЛАРТАЙ ХАРЬЦАХ ХАНШ**
2854.17 төг

**ТӨСВИЙН ТЭНЦЭЛ**
**-2739 тэрбум төг**

**ГАДААД ХУДАЛДАА**
**1219 сая АМ.ДОЛЛАР**

## ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

*Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.*



*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

## ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ**
**3698 САЯ АМ.ДОЛЛАР**

**ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ**
**11.3%**

**НИЙТ ХАДГАЛАМЖ**
**16.7 ИХ НАЯД ТӨГ**

**МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР**
**30.8 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР**

**ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ**
**950 ТЭРБУМ ТӨГ**

**МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ**
**8%**

## ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2020 онд:2.1%,
Инфляци: 2020 онд: 6.6%,
Урсгал тэнцэл: 2020 онд: -13%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны 4-р сарын тайланд төймлосон байна.

Эх сурвалж: https://bit.ly/2XR5XVj

ДНБ-ий өсөлт: 2020 онд: -1%
Инфляци: 2020 онд: 5.6%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2020 онд: -10.2%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: https://bit.ly/2XR5XVj

# САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЕСДҮГЭЭР САР 2020

## ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

### Төсвийн тэнцэл 9-р сарын байдлаар (2739) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 13.5 хувиар буурсан бол, зарлага 30 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2739 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 18.2 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




### Ам.долларын ханш өмнөх сараас 5 төгрөгөөр өсөв.

Есдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 184 төгрөг буюу 6.9 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 5 төгрөг буюу 0.18 хувиар, өмнөх улирлаас 1.35 хувиар өсч 2854.17 төгрөг болов. 9-р сард гадаад валютын нөөц 3.69 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 1 хувиар өсч, оны эхнээс 15 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

### Инфляцийн түвшин 1.7%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2020 оны 9-р сарын байдлаар өмнөх сараас 0.4 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар, оны эхнээс 2.3 хувь өсөв. Инфляцын түвшин 2017 оны 9 дүгээр сард 5.8 хувь, 2018 оны 9 дүгээр сард 5.7 хувь, 2019 оны 9 дүгээр сард 9 хувь гарч байсан бол 2020 оны 9 дүгээр сард 1.7 хувь болж, өмнөх оны мөн үеэс 7.3 пунктээр буурсан байна.

### Гадаад худалдааны тэнцэл 1219 сая.ам долларын ашигтай гарав.

2020 оны есдүгээр сард нийт барааны эргэлт 9075 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 13.9 хувиар буурсан бол экспорт өмнөх сараас 13.4, импорт өмнөх оны мөн үеэс 14.5 хувиар тус тус буурч гадаад худалдааны тэнцэл 1219 сая ам.долларын ашигтай гарав



## 9-Р САРЫН ОНЦЛОХ: ЗЭЭЛ




*Эх сурвалж: www.mongolbank.mn*

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 9-р сард өмнөх сараас 0.2 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 0.1 хувиар буурч 17.3 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1971 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.2 хувиар нэмэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 0.1 хувиар буурсан байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 11.3% байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 9 дүгээр сарын эцэст 1.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 11 (1.0%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 161.5 (16.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.6 хувийг эзэлж байна. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 9 дүгээр сарын эцэст 2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 4.6 (0.2%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 1.8 (0.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Уул уурхайн салбарын 3 зээл тутмын нэг нь, тээврийн салбарын 5 зээл тутмын нэг нь чанаргүйтэж байна. Оны эцэс, ирэх жилийн эхэнд чанаргүй зээл илүү их нэмэгдэх хандлагатай байгаа юм. Уул уурхайн салбарт гэхэд чанаргүй зээл 30 хувьд хүрэв. Хугацаа хэтэрсэн зээл, оны эхнээс 23 хувь, жилийн 34 хувь болон өсөж, 1 наяд төгрөгт хүрчээ. Энэ нь нийт зээлийн багцийн 5.8 хувийг бүрдүүлж байна. Иргэдийн хугацаа хэтэрсэн зээл жилийн 21 хувь, бизнесийнх 41 хувь өссөн байна.

## САРЫН ОНЦЛОХ

### ЭДИЙН ЗАСАГ 9.7 ХУВИАР БУУРАВ

- "COVID-19"-ийн цар тахлын нөхцөлд зайлшгүй хэрэгжүүлсэн хөл хорио, хилийн боомтуудыг хааснаар уул уурхай, худалдаа, тээврийн салбарт нөлөөлж, улмаар эдийн засаг 9.7 хувиар агшлаа. Энэ нь банкын салбарт нөлөөлж, I улиралд зээл олголт жилийн 2 хувиар, II улиралд хурдасч 11 хувиар буурчээ. Харилцах дансны үлдэгдэл оны эхний хагас жилд 9 хувиар бууралд зогсохгүй (Энэ нь төсвийн болон гадаадын хөрөнгө оруулалт буурсантай холбоотой), иргэдийн орлого доошилсноор хадгаламж барьцаалсан зээлийн олголт 3 хувиар өсөв.

### 1 АМ.ДОЛЛАР ТУТМЫН ЕРДӨӨ 1 ЦЕНТИЙГ ХОЙЧ ҮЕДЭЭ ХУРИМТЛУУЛЖ БАЙНА

- Монгол Улс сүүлийн 20 жилд эрдэс баялгаас олсон орлогын нэг ам.доллар тутмын ердөө нэг центийг хойч үедээ хуримтлуулж байгааг Дэлхийн банкны гаргасан шинэ тайланд дурджээ.Энэ хандлагыг өөрчлөхийн тулд Монгол Улс эрдэс баялгийн орлогоо хүний болон институцийн хөгжилд хөрөнгө оруулах замаар уул уурхайгаас хамаарах хамаарлаа бууруулах шаардлагатайг зөвлөв. Монгол Улс 2004 оноос хойш 28 тэрбум ам.долларын уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. Засгийн газар 2011 оноос Тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв санд сүүлийн 9 жилд 1,4 тэрбум ам.доллартай тэнцэх хуримтлал орж, 1,2 тэрбум ам.долларын зарцуулалт гарснаар цэвэр дүнгээр 0,2 тэрбум ам.долларын үлдэгдэлтэй байгаа юм.

*Эх сурвалж:*

1. *Статистикийн бюллетень, 9-р сар 2020 он, Үндэсний статистикийн хороо*
2. *Статистикийн бюллетень, 9-р сар 2020 он, Монголбанк*
3. *www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn,*